

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код 13.100

Хөдөлмөрийн аюулгүй, байдал эрүүл мэнд. Нэр томьёо, тодорхойлолт	MNS 4967:XXXX
Occupational safety and health. Terms and definition	MNS 4967:2000-ын оронд

Стандарт хэмжил зүйн газрын даргын оны дүгээр сарын ...-ны өдрийн ... дугаар тушаалаар батлав.

Энэ стандарт нь оны.....дүгээр сарын-ний өдрөөс эхлэн хүчинтэй.

1. Хамрах хүрээ

Энэхүү стандарт нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн холбогдолтой нэр томьёо, тодорхойлолтыг тогтооно.

2. Нэр томьёо, тодорхойлолт

2.1 Ажлын байр

Ажилтан хөдөлмөрийн гэрээний дагуу гүйцэтгэх ажил үүрэгтэйгээ холбоотой байнга ба түр хугацаагаар оршин байх буюу шилжин явах, ажил олгогчийн шууд ба шууд бус хяналтад байх газар.

2.1.1 Байнгын ажлын байр

Ажилтан тасралтгүй 2 цагаас илүү хугацаанд эсвэл өдрийн нийт ажлын цагийн 50-аас дээш хувьд ажил үүргээ гүйцэтгэдэг ажлын байр.

2.1.2 Байнгын бус ажлын байр

Ажилтан тасралтгүй ажиллах хугацаа 2 цагаас бага хугацаанд, эсвэл өдрийн нийт ажлын цагийн 50 хүрэхгүй хувьд ажил үүргээ гүйцэтгэдэг ажлын байр.

2.2 Ажлын бүс

Ажилтан байнга ба түр хугацаагаар ажилладаг, шалны төвшнөөс дээш 2 м хүртэлх өндрийн хамрах үйлдвэрлэлийн байрны орон зай.

2.3 Ажлын тусгай хувцас

Хөдөлмөрийн нөхцөл, ажил үүргийн онцлогт тохируулан үйлдвэрлэлийн сөрөг хүчин зүйлээс хамгаалах зорилгоор ажилтанд олгож байгаа хувцас.

2.4 Ахуйн байр

Ажилтан хөдөлмөрлөх хэвийн үйл ажиллагааг хангахад чиглэсэн тусгайлан төхөөрөмжилсөн хувцас солих, түр амрах, бие засах, усанд орох, дулаацах зэрэг зориулалтын өрөө, тасалгааг хэлнэ.

2.5 Аюулгүй ажиллагааны гэрчилгээ

Үйлдвэрлэлийн объект (ажлын байр, техник, тоног төхөөрөмж) ба түүний бодит байдал нь аюулгүй ажиллагааны шаардлагыг хангаж байгааг илэрхийлэх баримт бичиг.

2.6 Мэргэжлээс шалтгаалсан өвчин

Ажилтны бие махбодод хөдөлмөрлөх үүргээ биелүүлэх явцад үйлдвэрлэлийн сөрөг хүчин зүйлийн нөлөөллөөс шалтгаалан үүссэн өвчин эмгэг.

2.7 Үйлдвэрлэлийн аюултай хүчин зүйл

Тодорхой нөхцөлд ажилтны эрүүл мэндэд нөлөөлж гэмтээх буюу түүний эрүүл мэндийг гэнэт муутгах үйлдвэрлэлийн хүчин зүйл.

2.8 Үйлдвэрлэлийн байр

Үйлдвэрлэлийн ажиллагааг зохион байгуулах, хянах, удирдах, хөдөлмөрийн үйл ажиллагаагаа явуулах зориулалттай барилга, байгууламжийн тодорхой орон зай.

2.9 Үйлдвэрлэлийн осол

Ажилтан хөдөлмөрлөх үүргээ биелүүлэх явцад үйлдвэрлэлийн болон түүнтэй адилтгах аюултай хүчин зүйлийн нөлөөлөлд өртөж эрүүл мэндээр хохирох, амь насаа алдах.

2.10 Үйлдвэрлэлийн сургалт

Гарч болох эрсдэл болон авч хэрэгжүүлэх арга боломжийн тухай мэдээллийг бүх түвшинд шуурхай хүргэхэд чиглэгдсэн мэдээллийн үйл ажиллагааны нэр төрөл.

2.11 Үйлдвэрлэлийн хортой хүчин зүйл

Ажилтны эрүүл мэндэд нөлөөлж өвчлүүлэх буюу ажиллах чадварыг бууруулах, зарим тохиолдолд нөхөн үржихүйн эрхтэн тогтолцоонд сэргөөр нөлөөлөх үйлдвэрлэлийн хүчин зүйл.

ТАЙЛБАР: Хорын түвшин, үйлчлэх хугацаанаас хамаарч үйлдвэрлэлийн хортой хүчин зүйл аюултай хүчин зүйл болон хувирч болно.

2.12 Хордлого

Химийн, цацрагийн болон биологийн идэвхт бодис зэрэг хүний биед гаднаас янз бүрийн замаар нэвтрэн орж, бие махбодын хэвийн үйл ажиллагааг алдагдуулах, өвчлөл үүсгэхийг хэлнэ. Хордлого нь илрэх явцаар нь **хурц** болон **архаг** гэж ангилна.

2.12.1 Хурц хордлого

Ажилтан хөдөлмөрийн үүргээ гүйцэтгэх явцад химийн, цацрагийн болон биологийн идэвхт бодисын нөлөөнд богино хугацаанд их хэмжээгээр өртөж, хурц цочмог хэлбэрийн хордлого үүсэх бөгөөд энэ нь эрүүл мэндэд ноцтой хохирол учруулах, улмаар амь насанд аюул учруулах нөхцөл байдал.

2.12.2 Архаг хордлого

Химийн, цацрагийн болон биологийн идэвхт бодис удаан хугацаанд бага багаар бие махбодид нэвтэрснээс шалтгаалан аажимдаа өвчин эмгэг үүсгэх, биеийн хэвийн үйл ажиллагааг алдагдуулах хордлогын хэлбэр.

2.13 Хувийн хамгаалах хэрэгсэл

Ажилтны эрүүл мэндэд нөлөөлж болзошгүй үйлдвэрлэлийн аюултай болон хортой хүчин зүйлийн нөлөөллийг бууруулах буюу арилгах зорилгоор хэрэглэдэг техникийн хэрэгсэл.

2.14 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа

Үйлдвэрлэл, үйлчилгээний явцад техник, тоног төхөөрөмж, технологийн үйл ажиллагаанаас шалтгаалан ажиллагсдын эрүүл мэнд, хөдөлмөрлөх чадварт хохирол учруулж болох аливаа сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх эдийн засаг, техник, технологийн болон зохион байгуулалтын арга хэмжээг хэлнэ.

2.15 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн стандарт

Хөдөлмөрийн нөхцөл, аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар эрх бүхий байгууллагаас тогтоосон хэм хэмжээ.

2.16 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлага

Хөдөлмөрлөх явцад учирч болзошгүй аюул, эрсдэлээс урьдчилан сэргийлэх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор хууль тогтоомж, норматив техникийн баримт бичиг, дүрэм, зааварт тогтоосон хэм хэмжээ, шаардлага.

2.17 Хөдөлмөрийн нөхцөл

Хөдөлмөр эрхлэх явцад ажилтны хөдөлмөрлөх чадвар болон эрүүл мэндэд дангаар нь эсвэл хамтдаа нөлөөлөх үйлдвэрлэлийн орчны хүчин зүйлийн нийлбэр..

2.18 Хөдөлмөрийн хэвийн нөхцөл

Үйлдвэрлэлийн хортой болон аюултай хүчин зүйлийн нөлөөлөл ажилтанд нөлөөлөхгүй, эсвэл тэдгээрийн хэмжээ нь эрүүл ахуйн зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтрээгүй нөхцөл.

2.19 Хөдөлмөрийн хэвийн бус нөхцөл

Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлагын хүрээнд сөрөг нөлөөллийг нь арилгах боломжгүй, хөдөлмөрийн стандартад нийцээгүй нөхцөл..

2.20 Хөдөлмөрийн улсын хяналт

Хөдөлмөрийн тухай хууль, тогтоомжийг хэрэгжүүлэх, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлага, хөдөлмөрийн стандартын биелэлтийг хангуулах зорилгоор хийж буй захиргааны хяналт.

2.21 Хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч

Хөдөлмөрийн хяналтын асуудлаар мэргэшсэн, захиргааны хяналтыг хэрэгжүүлэх эрх үүрэг бүхий албан тушаалтан.

2.22 Хөдөлмөрийн чадвар алдалт

Эрүүл мэндийн байдал, архаг өвчин, гэмтэл эсвэл биеийн үйл ажиллагааны алдагдлын улмаас үндсэн мэргэжлийн болон түүнтэй адил түвшний ажил гүйцэтгэх боломжгүй болох бөгөөд эмчилгээ, нөхөн сэргээх үйл ажиллагаагаар бүрэн сэргээх боломжгүй, эсвэл хэсэгчлэн сэргээх нөхцөл бүхий байдал.

2.22.1 Хөдөлмөрийн чадвараа бүрэн алдах

Хөдөлмөрийн чадвараа 70 ба түүнээс дээш хувиар алдах.

2.22.2 Хөдөлмөрийн чадвараа хагас алдах

Хөдөлмөрийн чадвараа 10-70 хүртэл хувиар алдах.

2.23 Хөдөлмөрийн эрүүл ахуй

Үйлдвэрлэл, үйлчилгээний явцад химийн, физикийн болон биологийн хүчин зүйлээс шалтгаалан ажилтны бие бялдар, мэдрэл, сэтгэхүйд өөрчлөлт орж өвчлөх, хөдөлмөрийн чадвар алдахаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн арга хэмжээ.

2.24 Эрүүл мэндийн үзлэг

Ажилтан шинээр ажилд орох болон ажиллаж байх хугацаанд эмчийн үзлэг, лабораторийн болон бусад шаардлагатай шинжилгээг хийж, өвчин эмгэг илрүүлэх, эрүүл мэндийн дүгнэлт гаргах үйл ажиллагаа.

2.24.1 Эрүүл мэндийн урьдчилсан үзлэг

Тухайн ажил, мэргэжилд ажилтан эрүүл мэндийн хувьд тэнцэх эсэх, мөн уг ажил мэргэжил нь ажилтны өмнө нь байсан архаг өвчинд нөлөөлөх эсэхийг тодорхойлж, дүгнэлт гаргах зорилгоор хийдэг эрүүл мэндийн үзлэг.

2.24.2 Эрүүл мэндийн байнгын үзлэг

Ажилтны ажиллах явцад мэргэжлийн өвчин, хордлогоос урьдчилан сэргийлж, өвчнийг эхний үе шатанд нь илрүүлэн эмчлэх, эрүүлжүүлэх зорилгоор хийх эрүүл мэндийн үзлэг.

2.25 Аюулгүй техник

Ажилтны эрүүл мэндэд үйлдвэрлэлийн аюултай хүчин зүйлийн нөлөөллөөс хамгаалах, эсвэл болзошгүй нөлөөлөл үүсэхээс сэргийлэх зорилготой техник, зохион байгуулалтын үйл ажиллагаа болон техник хэрэгслийн нэгдсэн тогтолцоо.

ТӨГСӨВ